

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Түвдэн	Дугаар	L313
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Өлзийт сумын 2-р баг
Төрсөн газар	Өлзийт сум	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Яргайтын хийд буюу Баруун хурал, Бэйлийн хошууны хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХӨТ 006, ӨХӨТ 012
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 25	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Өлзийт Яргайтын хурал, Бэйлийн хошууны хүрээ

Жужа: Энэ сүм хэдэн ламтай байсан бэ?

Түвдэн: 20-иод лам нар байсан байх.

Жужа: Хэдэн дугантай байсан бэ?

Түвдэн: Гурван дугантай байсан. Нэг нь сүм нэртэй нэг тоосгон дуган байсан. Нэг нь модон дуган байсан. нэг нь дарь эхийн дуган гээд нэг байшин байдаг байсан юм.

Жужа: Энэ тоосгон байшин нь ямар дуган байсан бэ?

Түвдэн: Тоосгон байшин нь тэр сүмийн сахиус шахуу байсан юм. Богд ламын дуган байсан юм даа. Жинхэнэ сахиус нь бол урд модон дугандаа байсан юм. Улаан сахиустай байсан юм.

Энхбаяр: Хэдэн суварга байсан?

Түвдэн: Их олон суварга байгаагүй. ганц л суварга байсан.

Жужа: Энэ хийдийн хашаан дотор байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Түвдэн: Аа хашаатай байсан. Тууруйн хэрэмтэй байсан юм. Тэр дээрээ тийм бааюутай, туурий шохой түлдэг. Тэрэн дээрээ туурийгаа , шохойгоо түлж байсан.

Жужа: Зурж авбал энэ сахиусны дуган хаанаа байсан бэ?

Түвдэн: Жинхэнэ сахиусны модон дуган урд талдаа байсан юм. Тоосгон дуган нь хойд талдаа байсан. Нөгөө дуган нь баруун талдаа байсан.

Жужа: Тэр суварга хаана байсан бэ?

Түвдэн: Суварга нь баруун хойд талдаа байсан.

Жужа: Хэдэн жастай байсан?

Түвдэн: нэг л жастай байсан.

Жужа: Ямар нэгэн тахидаг овоо байсан уу?

Түвдэн: Тэр жинхэнэ тахидаг овоо нь ойрхон байгаагүй. Баруун хайрхан гэдэгт нэг овоо байсан.

Жужа: Хамба лам нь хэн байсан бэ?

Түвдэн: Хамба лам нь хувилгаан Чимэддорж гэдэг хүн байсан юм. Тэр хүн баригдаад буудуулсан юм. Богдын дэргэд таван давхар олбогтой байдаг байсан юм.

Жужа: Энэ хийдэд ганжуур эргэдэг байсан уу, ямар ямар хуралтай байсан бэ?

Түвдэн: Ганжуур эргэдэг байсан. Цаг тутмын хуралтай байсан юм. Зуны хурал, өвлийн хурал гэж байдаг. Ганжууртай байсан юм. Ганжуурыг нь тэр хэлмэгдэлтийн үеэр нэг хүн шатаачихсан юм. 2000 гүрэмтэй, 2000 гандантай хурал хурдаг байсан юм. Зуны хурал нь гомбо сахиус хурдаг байсан юм.

Жужа: Тэнд өөр нэр алдартай лам нар байсан уу?

Түвдэн: Байсан. Гавж нэг л байсан. Эмч хүн нэг байсан юм.

Жужа: Нүгнээ сахидаг байсан уу?

Түвдэн: Нүгнээ сахиж байгаагүй.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Түвдэн: Хайлан хурдаг байсан.

Жужа: Төвдөөс лам нар байсан уу?

Түвдэн: Төвдөөс лам нар байгаагүй.

Энхбаяр: Гэлэн лам нар хэр олон байсан?

Түвдэн: Гэлэн сахилтай 4, 5 лам байсан.

Жужа: Лам нар яг хаана хаана амьдардаг байсан бэ?

Түвдэн: Тэрэн дээрээ гэртэй байшинтай байдаг байсан юм.

Жужа: Эргэн тойронд?

Түвдэн: Тийм, зарим нь хөдөөнөөс ирж хурал хурдаг байсан юм.

Жужа: Тэгээд энэ зоч лүйжинч лам нар байсан уу?

Түвдэн: Байгаагүй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хандмаа нар байсан уу?

Түвдэн: Байгаагүй. Манай хошуунд зоч лүйжин тавьдаг лам ганц л байсан. Тэр сүм дээр суудаг өвгөн.

Жужа: Та хэдэн он хүртэл тэнд шавилан сууж байсан бэ?

Түвдэн: Би 1920 онд хар болсон.

Жужа: Энэ хийд яг хэзээ хаагдсан бэ?

Түвдэн: Энэ хийд хэлмэгдэлтийн үед жаахан хаагдаж байгаад хойно сэргээгээд тэгээд одоо хүртэл хэвээрээ шахуу л байгаа юм даа. Дашчойлин нэртэй байгуулагдсан юм байна лээ. Хуучин сүм нэртэй байсан юм. Хоёр сүм байсан юм. Баруун сүм, зүүн сүм гэж. Зүүн сүмийг нь дээр үед Тээлийн хүрээ гэдэг рүү зөөчихсөн юм гэнэ лээ.

Энхбаяр: Энэ одоо та аль сүмийн тухай ярьж байна?

Түвдэн: Баруун сүмийн тухай ярьж байна.

Энхбаяр: Тээлийн хүрээ гэдэг нь хаана байдаг юм?

Түвдэн: Энэ дээр Горхинт гэж байсан юм даа, Сүмбэр уулын ард бий.

Жужа: Тэгэхээр энэ зүүн сүм хэдэн дугантай байсан бэ?

Түвдэн: Олон ламтай байгаагүй. Баруун сүмээс лам өгч хааяа хааяа хуралдана.

Жужа: Дуган байсан уу?

Түвдэн: Ганцхан дуган байсан. Модон дуган.

Жужа: Баруун сүмийн лам нар хэзээ тэр зүүн хүрээн дээр очиж хурдаг байсан юм?

Түвдэн: Голцуу өвлийнхөө хурлаар л очиж хурдаг байсан. Зуны хурлаар ч нэг их очдоггүй байсан юм.

Жужа: Хуучин засаг захиргааны дагуу яг ямар нэртэй хошуу байсан бэ?

Түвдэн: Түшээт хан аймгийн Тээлийн хошуу гэдэг байсан юм.

Жужа: Баруун хүрээ, зүүн хүрээ хэдэн км-ын зайтай байсан бэ?

Түвдэн: Нэг км-ын зайтай байсан.

Жужа: Та бага байхдаа өөр хүрээ хийд дээр очиж байсан уу?

Түвдэн: Би очиж байсан л даа. Энэ Тээлийн хүрээн дээр айраг энэ тэр уух гэж л очиж байсан байх.

Жужа: Том хүрээ байсан биз?

Түвдэн: Том хүрээ байсан.

Жужа: Хэдэн ламтай байсан?

Түвдэн: Тээлийн хүрээ дээр үед дугандаа багтахгүй, дуган нь дэлбэрч байсан юм гэнэ лээ. Их олон ламтай. Тээлийн хүрээ гэдэг чинь 15 дугантай байсан юм.

Жужа: Баруун хурал хэзээ байгуулагдсан бэ?

Түвдэн: Тээлийн хошуунаасаа л өмнө байгуулагдсан юм гэнэ лээ. Би сайн мэдэхгүй.

Жужа: Тээлийн хошууны хүрээ ямар ямар дацантай байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Түвдэн: Өө тэр олон. Чойрынх, цогчингийнх, ламирангийнх мамбынх энэ тэр гээд л өчнөөн дацантай их том хийд байсан юм.

Жужа: Зоч лүйжин тавьдаг лам нар байсан уу?

Түвдэн: Мэдэхгүй, байхгүй.

Жужа: Ямар нэгэн хутагт хувилгаан байсан уу?

Түвдэн: Байсан. Тээлийн лам гэж хутагт байсан. Бас баригдаад явсан. Би нэрийг нь сайн мэдэхгүй байна.

Жужа: Тэнд цам бүжиг гардаг байсан уу?

Түвдэн: Цам байхгүй. Цам гэдэг чинь хойт ард Далай гүний хүрээ гэдэг тэрэн дээр л их том цамтай газар байсан.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Түвдэн: Майдар эргэдэг байсан. Энэ хойно Далай гэж газар бий, тэрэн дээр дүлцэн эргэдэг, ганжуур эргэдэг тийм газар байсан.

Жужа: Хүрээний эргэн тойронд борчууд амьдардаг байсан уу?

Түвдэн: Байсан, зөндөө байсан.

Жужа: Хэдэн хүн байсан?

Түвдэн: Тэрийг би яаж мэдэхэв. Эргэн тойрон борчууд гээд айлууд их л байсан.

Жужа: Тэнд тоосгон дуган байсан уу, модон дуган байсан уу?

Түвдэн: Тоосгон олон байгаагүй байх голцуу модон дуган л байсан.

Жужа: Суварга байсан уу, хэдэн суварга байсан?

Түвдэн: Суварга байсан. Лав л баруун хойд талд найман суварга гэж байсан. Тэрийг би сайн мэдэх юм.

Жужа: Та энэ өндөр гэгээн Занабазарын төрсөн нутгийн талаар мэдэх үү?

Түвдэн: Өндөр гэгээн Занабазар гэдэг энэ Есөн зүйл сумын зүйлийн суварга гэж байгаа. Тэрнээс өмнө голын баруун талд дэрсэн дотор ганцхан дуган байсан юм. Тэнчээ өндөр гэгээн Занабазар мэндэлсэн юм гэнэ лээ.

Жужа: Тэр яг ямар нэртэй газар вэ?

Түвдэн: Зүйлийн гол гэдэг газар.

Жужа: Тэр тогтмол хуралтай байсан уу?

Түвдэн: Байнгын хуралтай байсан.

Жужа: Тэнд хэд орчим лам нар очдог байсан?

Түвдэн: Тэрийг би яаж мэдэхэв. Арав хориод лам нар байсан биз.

Жужа: Ганцхан дуган байсан гэсэн тийм ээ?

Түвдэн: Тийм, тэр ганц дуган нь өндөр гэгээний мэндэлсэн өвгөн суварга гэж.

Жужа: Тэр модон дуган байсан уу?

Түвдэн: Модон дуган байсан.

Жужа: Суваргын дэргэд үү?

Түвдэн: Тийм, тэр суваргыг л хамгаалж л барьсан дуган гэдэг юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Тэгээд энэ баруун хурлыг сэргээсэн гэсэн тийм ээ?

Түвдэн: Тийм, сэргээсэн юм.

Жужа: Энийг хэн хэн сэргээсэн бэ?

Түвдэн: Одоо өнгөрсөн байх аа, тэр Магалжав гэдэг лам барьсан юм.

Жужа: Тэр бас өмнө нь Баруун хурлын лам байсан уу?

Түвдэн: Өмнө нь лам байсан мөртлөө эмч хүн байсан юм. Тэгээд эцэг нь эмч хүн байсан юм. Тэр Магалжав сэргээгээд хоёр гурван жил болж байсан юм. Өнгөрдөг жил нас барсан даа.

Жужа: Тэгээд тэр шинэ дуганд хэдэн лам байна вэ?

Түвдэн: Одоо нэг хоёр, гурван лам байгаа байх.

Жужа: Таниас гадна энэ баруун хурлын лам бий юу?

Түвдэн: Байхгүй.

Жужа: Энэ Баруун, зүүн хурал ямар нэртэй газар байсан бэ?

Түвдэн: Энэ Яргайтын сүм л гэж, тэр Яргайт уулын тэнд.

Жужа: Тахидаг рашаан овоо байсан уу?

Түвдэн: Тахидаг овоо нь ойр байгаагүй. Рашаан нь Хайлангийн гол гэж рашаан байсан юм.

Жужа: Тэр сүмийн аль тийшээ байсан бэ?

Түвдэн: Баруун өмнө. Сүмээсээ баруун урагшаа 100-аад метр байсан байх.

Жужа: Хийд мал сүрэгтэй байсан уу?

Түвдэн: Мал сүрэгтэй байсан.

Жужа: Тэр зүүн сүм нь ямар нэртэй газар байсан бэ?

Түвдэн: Бас л тэр Яргайтын уулын тэнд, хоорондоо нэг км л зайтай байсан юм.

Жужа: Зүүн хурал хэзээ хаагдсан бэ?

Түвдэн: Зүүн хүрээ нь аль эрт хаагдсан юм.

Жужа: Тээлийн хүрээ хэзээ хаагдсан бэ?

Түвдэн: Тэр лам нар баригдсан үед л хураагдсан юм.

Жужа: Тэгээд та хар болоод ямар ажил хийж байсан бэ?

Түвдэн: Би хар болоод хөдөө амл маллаж байгаад цэрэгт явсан юм. Цэрэгт яваад 5 жил болоод ирсэн.

Жужа: Энэ олон сүсэгтэн ирдэг байсан уу?

Түвдэн: Олон сүсэгтэн байсан юм.

Жужа: Лам нар аль аль сумаас ирдэг байсан бэ?

Түвдэн: Энэ нутгаасаа л ирдэг байсан .

Жужа: Их хүрээнээс ирдэг байсан уу?

Түвдэн: Их хүрээнээс ирдэг байсан.

Жужа: Эрдэнэ зуугаас лам нар ирдэг байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Түвдэн: Эрдэнэ зуугаас бараг ирж байгаагүй байх аа. Үгүй ээ, ирж байсан ч юм билүү яаж мэдэх вэ дээ.

Жужа: Гэр хэлбэртэй дуган байсан уу?

Түвдэн: Байгаагүй.

Жужа: Дандаа дөрвөлжин?

Түвдэн: Дандаа дөрвөлжин, хойно тэр нэг хоёр шавар гэр дуган байсан.

Жужа: Танд өөр хэлэх юм байна уу?

Түвдэн: Өөр юу байхав дээ.

Жужа: Өвөрхангай аймагт өөр хүрээ хийд байсан уу?

Түвдэн: Өвөрхангай аймагт өөр хүрээ бараг байгаагүй. Харин саяхнаас л нэг хийдтэй болсон гэж яриад байгаа юм.

Жужа: За болсон.